



**СҮХБААТАР АЙМГИЙН БАРУУН-УРТ
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 08 сарын 14 өдөр

Дугаар 6/06


Баруун-Урт сум

「 Хог хаягдлын үйлчилгээний хураамж
шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10 дахь заалт, 35.1.14 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.2 дахь хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалт, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 192, А/243 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит Зургаадугаар Хурлаас ТОГТООХ нь:

1. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн шинэчлэн батлагдсан үнэ, тарифыг иргэдэд мэдээлж, төлбөрийг төсөвт цаг хугацаанд нь төвлөрүүлэн зохих журмын дагуу зарцуулж хагас жил, жилээр биелэлт, үр дүнг сумын Засаг даргад танилцуулж ажиллахыг “Сүхбаатар тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын дарга (Х.Баатарсүх)-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын бүрдүүлбэрийг хангаж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж бүртгүүлэхийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (М.Хүрэлтогоо)-д үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 04 дүгээр тогтоолыг хүчингүйд тооцсугай.
5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (М.Хүрэлтогоо)-д даалгасугай.

ДАРГА



Г.ИДЭРМӨНХ